

“MNS 6597 Холбооны кабель шугамыг авто зам, төмөр зам хөндлөн гарах болон гүүрний байгууламжаар дамжуулан суурилуулах ерөнхий шаардлага” стандартын төслийн саналын нэгдсэн товчоо

2019 оны 03 дугаар сарын ... өдөр

Улаанбаатар хот

“MNS 6597 Холбооны кабель шугамыг авто зам, төмөр зам хөндлөн гарах болон гүүрний байгууламжаар дамжуулан суурилуулах ерөнхий шаардлага” стандартын төсөлд дараах саналууд ирснийг тусгалаа. Үүнд:

1. Зам тээврийн хөгжлийн яам /Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ, Нийслэлийн авто замн хөгжлийн газар, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, Монголын төмөр зам ТӨХК-аас ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж ирүүлсэн./
2. Зам тээврийн хөгжлийн төв
3. Радио телевизийн сүлжээ УТҮГ

№	Стандартын заалт	Төслийн эхний хувилбар	Саналын товч агуулга	Саналыг тусгасан эсэх	Тайлбар
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ					
1	1.2	Энэ стандартыг авто зам, төмөр зам, гүүр байгуулах зураг төсөв боловсруулах, мэдээлэл холбооны сүлжээний зураг төсөв боловсруулах, автозам, төмөр зам, гүүрийн байгууламжийн болон харилцаа холбооны суурилуулалт, техникийн засвар үйлчилгээ хийх аж ахуйн нэгж, иргэд мөрдөн ажиллана.	<i>Найруулгыг сайжруулах</i> Энэ стандартыг төмөр зам, авто зам байгууламж , зураг төсөв боловсруулах, мэдээлэл холбооны сүлжээний зураг төсөв боловсруулах, авто зам, төмөр зам, гүүрийн байгууламжийн болон харилцаа холбооны суурилуулалт, техникийн засвар үйлчилгээ хийх аж ахуйн нэгж, иргэд дагаж мөрдөн ажиллана.	Саналыг хүлээн авч тусгасан	
2	2	байхгүй	Норматив ишлэл-д Төмөр замын холбогдох журам, авто замын норм, дүрмүүдийг нэмж тусгах	Саналыг хүлээн авч тусгасан	
3	3.3	Цайрдсан төмөр хоолой	Одоо мөрдөж байгаа MNS 6597:2016 стандартад ган хоолой ашиглахаар заасан байгаа. Цайрдсан төмөр хоолойг ашиглах болсон шалтгаанаа үндэслэлийг тайлбарлах		Ган хоолой нь зах зээлд олдоц муутай, үнийн хувьд өндөр байгаа тул практикт механик гэмтлээс хамгаалах, зэврэлтээс хамгаалах зорилгоор цайрдсан төмөр хоолойг ашиглаж байгаа
4	4.1a	Авто замын асфальтан хучилтын дор хөндлөн байршуулсан цайрдсан төмөр хоолойгоор	<i>Нэр томъёоны тодорхойлолтыг ашиглах</i> Авто замын хатуу хучилтын дор	Саналыг хүлээн авч тусгасан	

		хамгаалалтын уян хоолой хийж гаргах	Хөндлөн байршуулсан цайрдсан төмөр хоолойгоор хамгаалалтын уян хоолой хийж гаргах		
5	4.3	Холбооны кабель шугамыг авто замаар хөндлөн суурилуулахдаа харъяалагдах хот суурин, орон нутгийн авто замын газраас албан ёсны зөвшөөрөл авч ажлыг гүйцэтгэнэ.	<i>Найруулгыг сайжруулах</i> Холбооны кабель шугамыг авто замаар хөндлөн суурилуулах болон гүүрэн байгууламжаар дамжуулан гүйцэтгэхдээ харъяалагдах хот суурин, орон нутгийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авч ажлыг гүйцэтгэнэ.	Саналыг хүлээн авч тусгасан	
6	5.4	Авто замын 2 талд суурилуулалтын ажлыг хийхэд ашиглах болон кабелийн нөөц үлдээх зориулалт бүхий нөөц нүх эсвэл холбооны худгийг авто замын хөвөөнөөс 5 м-ээс багагүй зайд байрлуулна.	<i>Найруулгыг сайжруулах</i> Авто замын 2 талд суурилуулалтын ажлыг хийхэд ашиглах болон кабелийн нөөц үлдээх зориулалт бүхий нөөц нүх эсвэл холбооны худгийг авто замын хөвөөнөөс гадна налуугийн ёроолоос 5 м-ээс гадагш, замын өөрийн шуудууны гадна налуугийн ирмэгээс гадагш 5м-ээс доошгүй зайд байрлуулна.	Саналыг хүлээн авч тусгасан	
7	6.1	Хот суурин газарт авто замыг шинээр төлөвлөж байгуулахдаа 50м тутамд авто замын асфальтан хучилт дор холбооны кабель шугамыг суурилуулахад зориулсан цайрдсан төмөр хоолой хөндлөн байршуулна.	"Авто зам төсөллөх" норм ба дүрэм (ЗЗБНБД 22-004-2016)-д дээрх асуудал тусгагдаагүй тул уг 6.1 заалтыг хасах. Цайрдсан төмөр хоолой байршуулах бол нэг маягийн зургийн техникийн шаардлага, үйлдвэрлэлийн болон төсвийн жишиг нормд тусгуулан батлах шаардлагатай. Мөн замын төсөв ихээр нэмэгдэх тул хасах.		
8	7	Авто замын ус зайлуулах дугуй, дөрвөлжин хоолойгоор хамгаалалт хийж гаргах	Геодези усны барилга байгууламжийн газраас санал авах	Саналыг хүлээн авч тусгасан	7-р бүлгийг бүхэлд нь хассан
9	7.1	Ус зайлуулах хоолойны доод түвшингээс 40 мм-ээс доошгүй зайнд цайрдсан төмөр хоолойг ус зайлуулах хоолойны хананд бэхэлж байрлуулна. Цайрдсан төмөр хоолойны гадуур бетонон хамгаалалтыг хайрцаглаж хийнэ	УМ зайлуулах хоолойны доод түвшин гэдэг нь хоолойн улны төвшин гэж ойлгогдож байгаа бөгөөд холбооны шугамыг хоолой доогуур хийхээр ойлгогдож байна. Цайрдсан төмөр хоолойг ус зайлуулах хоолой хананд бэхэлж суурилуулахдаа хоолойн ашиглалтын байдал, бат бэхэд нөлөөлөхгүй байхаар тооцоог хийхээр тусгах шаардлагатай.		

10	3-р зураг	Авто замын ус зайлуулах хоолойгоор хамгаалалт хийж хөндлөн гаргах	3-р зургийг орхигдуулсан байна.		
11	8	Авто замыг сэтлэлгүйгээр хамгаалалтын цайрдсан төмөр хоолой ашиглан буудаж зам хөндлөн гаргах	Энэхүү 8-р бүлэгт тусгагдсан (jacking method) арга, аргачлалыг нарийвчлан тодорхой боловсруулах. Энэ арга нь уг стандартын төслийн 5-р бүлэгт хэрхэн хамаарч байгаа нь тодорхойгүй байна.	Саналыг хүлээн авч тусгасан	
12	9.3	Агаарын баганат шугам суурилуулахдаа 11 м хүртэлх урттай бетонон багана ашиглах ба авто замын хөвөөнөөс агаарын багана хүртэлх зай нь 5м-ээс багагүй байна.	Агаарын баганат шугам суурилуулахдаа 11 м хүртэлх урттай бетонон багана ашиглана. Суурилуулсан кабелийн унжилтын доод цэг нь авто замын зорчих хэсгийн тэнхлэг хүртэл зай 7.5м-ээс багагүй өндөртэй байна.	Саналыг хүлээн авч тусгасан	
13		Байхгүй	<i>Шинээр нэмж оруулах</i> Агаарын баганат шугам суурилуулахдаа авто замын хөвөөний хоёр талын налуу, түүний ёроол болон замын ухмалын хэсэгт баганат шугам байрлуулахыг хориглоно.	Саналыг хүлээн авч тусгасан	
14	4-р зураг	Авто замыг агаарын баганат шугамаар хөндлөн гаргах	4-р зураг дээр Суурилуулсан кабелийн унжилтын доод цэг нь авто замын зорчих хэсгийн тэнхлэг хүртэлх зай 7.5м-ээс багагүй өндөртэй байна гэж заах Мөн авто замын хөвөөний 2 талын налуу, түүний ёроолыг уш зурагт тусгах	Саналыг хүлээн авч тусгасан	
15	10.5	Ажил гүйцэтгэсний дараа авто замыг авто замын тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн компаниар сэргээлгэж холбогдох байгууллагад хүлээлгэж өгнө.	<i>Найруулгыг сайжруулах</i> Ажил гүйцэтгэсний дараа авто замыг авто замын тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн компаниар сэргээлгэж зам, замын байгууламж хариуцагч байгууллагад хүлээлгэж өгнө.	Саналыг хүлээн авч тусгасан	
16	10.6	байхгүй	<i>Заалт нэмж оруулах</i> Авто замын хариуцагч байгууллагаас зам сэтлэх зөвшөөрөл авна.	Саналыг хүлээн авч тусгасан	
17	12.1	Кабелийг шууд булах тохиолдолд авто замыг сэтлэх өргөн нь 30см-ээс багагүй	<i>Найруулгыг сайжруулах, нэмэх</i> Кабелийг шууд булах тохиолдолд авто замыг сэтлэх өргөн нь 50см-ээс багагүй өргөнтэй байх ба шуудууны гүн нь 1.5м-ээс багагүй байна.	Саналыг хүлээн авч тусгасан	

		өргөнтэй байх ба шуудууны гүнь нь 1.5м-ээс багагүй байна.	Зам барилгын ажлын техникийн шаардлагын дагуу нягтруулна.		
18	12.3	байхгүй	<i>Шинэ заалт нэмж оруулах</i> Зам тээврийн сайдын 2016 оны 37 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн арчлалт, урсга засвар, онцгой ажлуудыг гүйцэтгэх хугацааны норм", "Авто зам, замын байгууламжийн арчлалт, завсарын зохион байгуулалтын техникийн дүрэм" бусад холбогдох норм ба дүрмүүдийг баримтлан ажлыг гүйцэтгэх.	Саналыг хүлээн авч тусгасан	
19		13.1-ийн "а/ Төмөр замын гарцыг ашиглан суурилуулалт хийх"	Төмөр замын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа тул Төмөр замын нүхэн гарцыг ашиглан холбооны кабель суурилуулалт хийх аргыг хасах	Саналыг хүлээн авч тусгасан	14-р бүлгийг бүхэлд нь хассан
20	13.2	Холбооны кабель шугамыг төмөр замаар хөндлөн суурилуулахад харъяалагдах хот суурин, орон нутгийн төмөр замын газар, албадаас албан ёсны зөвшөөрөл авч төмөр замын тухайн хэсгийг хариуцан ажиллах дохиочны хяналтан дор ажлыг гүйцэтгэнэ.	<i>Холбогдох журмыг үндэслэх</i> Холбооны кабель шугамыг төмөр замаар хөндлөн суурилуулахдаа төмөр замын зураг төслийн эрх бүхий байгууллагын баталсан зургийн дагуу хийх бөгөөд Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авч төмөр замын тухайн хэсгийг хариуцан ажиллах ажилтны хяналтан дор хийж гүйцэтгэнэ.		
21	16.6.1	Гүүрэнд цайрдсан төмөр хоолой бэхлэхдээ тухайн гүүрний зураг төслийн авторын зөвшөөрлийг авч гүйцэтгэнэ.	<i>Найруулгыг сайжруулах</i> Цайрдсан төмөр хоолой гүүрэнд бэхлэхдээ тухайн гүүрийг хариуцагч байгууллага, зураг төслийн зохиогчийн зөвшөөрлийг авч хяналтан дор гүйцэтгэнэ.	Саналыг хүлээн авч тусгасан	
22	16.6.2	Гүүрэнд зориулалтын сувагчлал байхгүй тохиолдолд гүүрэнд цайрдсан төмөр хоолойг гүүрний зөвшөөрөгдсөн хэсэгт бэхэлж холбооны кабель шугамыг ил суурилуулна.	<i>Найруулгыг сайжруулах</i> Гүүрэнд зориулалтын сувагчлал байхгүй тохиолдолд гүүрэнд цайрдсан төмөр хоолойг гүүрний зөвшөөрөгдсөн хэсэгт бэхэлж холбооны кабель шугамыг ил буюу хайсны гадна ёроолд суурилуулна.	Саналыг хүлээн авч тусгасан	
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ					

23	1.1	Энэ стандартаар холбооны кабель шугамын угсралт суурилуулалтыг авто зам, төмөр зам хөндлөн гаргах болон гүүрэн байгууламжаар дамжуулан гүйцэтгэхэд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлно.	Энэ стандартаар холбооны кабель шугамын угсралт суурилуулалтыг төмөр зам, авто замын байшууламжаар дамжуулан хөндлөн гаргах байгууламжаар дамжуулан гүйцэтгэхэд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлно.	Саналыг хүлээн авч тусгасан	
24	3.2	Буудаж гаргах	<i>Сүвэгчлэх</i>		
25	4.1 б	Замын ус зайлуулах дугуй, дөрвөлжин хоолойгоор цайрдсан төмөр хоолойгоор хамгаалалт хийж гаргах	<i>Энэ заалтыг хасах Авто замын салбарт энэ ажлыг хориглоно.</i>	Саналыг хүлээн авч тусгасан	14-р бүлгийг бүхэлд нь хассан
26	4.3	Холбооны кабель шугамыг авто замаар хөндлөн суурилуулахдаа харъяалагдах хот суурин, орон нутгийн авто замын газраас албан ёсны зөвшөөрөл авч ажлыг гүйцэтгэнэ.	Холбооны кабель шугамыг авто замаар хөндлөн суурилуулахдаа харъяалагдах хот суурин, орон нутгийн Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авч ажлыг гүйцэтгэнэ.	Саналыг хүлээн авч тусгасан	7-р бүлгийг бүхэлд нь хассан
27	6	Авто замын асфальтан хучилтын дор хөндлөн байршуулсан цайрдсан төмөр хоолойгоор хамгаалалтын уян хоолой хийж гаргах	Асфальтбетон, цементбетон болон ямарч хучилт байж болно. Авто замын хатуу хучилтын дор хөндлөн байршуулсан цайрдсан төмөр хоолойгоор хамгаалалтын уян хоолой хийж гаргах	Саналыг хүлээн авч тусгасан	
28	7.1	Ус зайлуулах хоолойны доод түвшингээс 40мм-ээс доошгүй зайнд цайрдсан төмөр хоолойг ус зайлуулах хоолойны хананд бэхэлж байрлуулна. Цайрдсан төмөр хоолойны гадуур бетонон хамгаалалтыг хайрцаглаж хийнэ.	Ус зайлуулах хоолойны доод түвшингээс (тодруулах ойлгомжгүй байна) 40мм-ээс доошгүй зайнд цайрдсан төмөр хоолойг ус зайлуулах хоолойны хананд бэхэлж байрлуулна. Цайрдсан төмөр хоолойны галуур бетонон хамгаалалтыг хайрцаглаж хийнэ.	Саналыг хүлээн авч тусгасан	7-р бүлгийг бүхэлд нь хассан
29	9.3	Агаарын баганат шугам суурилуулахдаа 11 м хүртэлх урттай бетонон багана ашиглах ба авто замын хөвөөнөөс агаарын багана хүртэлх зай нь 5м-ээс багагүй байна.	Агаарын баганат шугам суурилуулахдаа 11м хүртэлх урттай бетонон багана ашиглах ба авто замын хөвөөний гадна налуугийн ёроолоос болон замын өөрийн шуудууны гадна налуугаас гадагш, замын ухмалын хэсэгт баганат шугам байрлуулахыг хориглоно.	Саналыг хүлээн авч тусгасан	

30	4-р зураг	Авто замын агаарын баганат шугамаар хөндлөн гаргах	<i>Зураг дээр агаарын баганы өндрийг зааж өгөх бм-ээс дээш</i>	Саналыг хүлээн авч тусгасан	
Радио телевизийн сүлжээ УТҮГ					
31		Авто зам, төмөр зам хөндлөн гарах болон гүүрэн байгууламжид холбооны кабель шугамыг суурилуулах ерөнхий шаардлага	Шинээр барих авто зам, төмөр зам хөндлөн гарахад газар доорхи кабель сувагчлалын янданг шинээр хийж монтажлах талаар тусгах		

--oOo--